



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/572

Хэрлэн сум

Таримал ойг улсын ойн санд
хүлээж авах, тооллого хийх ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5, 30.6 дахь хэсгүүд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, сангийн сайдын хамтарсан 2013 оны “Журам батлах тухай” А-96/71 дугаар тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинээр болон шинэчлэн батлах тухай” А/172,116 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хэнтий аймагт тарьж ургуулсан таримал ойг улсын ойн санд хүлээж авах, тооллого хийх ажлыг Батширээт сумын “Асгатын зоо” нэртэй газарт 2012 онд “Эв-Эе” нөхөрлөлийн тарьсан 3 га талбайн таримал ойд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, Дадал сумын “Цээнэтэй” нэртэй газарт 2017 онд “Цагаанбулаг андууд” ХХК-ийн хариуцан тарьж ургуулсан 5 га талбайн таримал ойд зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

2.Таримал ойн тооллогыг хууль журмын дагуу зохион байгуулж, холбогдох материалыг Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Б.Мөнхжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
..... дугаар сарын.....-ны өдрийн
..... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

- | | | |
|-----------------------|--------------|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Б.Мөнхжаргал | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Нарийн бичиг: | Б.Гүрсүрэн | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны мэргэжилтэн |
| Гишүүд: | Ш.Шинэбаяр | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хорооны гишүүн (Зөвшилцсөнөөр) |
| | Г.Гансүх | Батширээт сумын Засаг дарга |
| | Б.Мөнхбаяр | Иргэний төлөөлөл, ахмад ойн инженер (Зөвшилцсөнөөр) |



Аймгийн Засаг даргын 2023 оны
..... дугаар сарын.....-ны өдрийн
..... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

- Ажлын хэсгийн
ахлагч: Б.Мөнхжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Нарийн бичиг: Б.Гүрсүрэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
Ойн албаны мэргэжилтэн
- Гишүүд: Ш.Шинэбаяр Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
төлөөлөгч, Байгаль орчин, аялал жуулчлал,
хөдөөгийн хөгжлийн хорооны гишүүн
(Зөвшилцсөнөөр)
- Д.Мөнх-Од Дадал сумын Засаг дарга
- Б.Мөнхбаяр Иргэний төлөөлөл, ахмад ойн инженер
(Зөвшилцсөнөөр)